

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН НЭГДСЭН ЗОХИЦУУЛАЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ ШИЖЭЭГИЙН МӨНГӨНЦЭЦЭГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудын уялдаа холбоог сайжруулах, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах, албан хаагчдад хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа							
1.	Арга хэмжээ 1.1. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Засгийн газарт эрх олгосон хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг гаргах	Эрх олгосон хуулийн зохих заалтын хэрэгжилтийн тоо	-	Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргэгдсэн байна.	Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Донорын тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль, Тамхины хяналтын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр	01-03	100 хувь

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар Засгийн газарт эрх олгосон хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг гаргав. Дээрх хуулиудын 20 заалтаар Засгийн газарт эрх олгосон байх ба 14 заалтыг хэрэгжүүлж, Засгийн газраар батлуулсан байна. Харин 6 заалтыг хэрэгжүүлээгүй, Засгийн газраар батлуулаагүй байна. Хэрэгжилтийг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 1а/167 дугаар албан бичгээр хүргүүлсэн.		
2.	Арга хэмжээ 1.2. Яамнаас батлан гаргасан захиргааны хэм хэмжээний актуудын хуульд нийцсэн байдал, тэдгээрийн хоорондын уялдааг хангах, давхардал, зөрчлийг арилгах асуудлыг судлан үзэж, нэгдсэн	Дүн шинжилгээ хийсэн шийдвэрийн тоо	-	Санал, дүгнэлт боловсруулагдаж ХЗДХЯ-нд хүргэгдсэн байна.	Яамнаас батлан гаргасан нийт 84 захиргааны хэм хэмжээний актуудын хуульд нийцсэн байдал, тэдгээрийн хоорондын уялдааг хангах, давхардал, зөрчлийг арилгах асуудлыг судлан, дүн шинжилгээ хийж, санал дүгнэлт боловсруулан дүнг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2025 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 1а/1717 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	01-04	100 хувь

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	санал, дүгнэлт боловсруулна.						
3.	Арга хэмжээ 1.3. Хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн шийдвэрүүдийг хүчингүй болгох тушаалын төслийг боловсруулна.	Хүчингүй болгох тушаалын төслийн тоо	-	Тушаалын төсөл холбогдох байгууллагад хүргэгдсэн байна.	Хүчин төгөлдөр үйлчилж буй Биеийн тамир, спортын тухай хуулиар тусгайлан эрх олгоогүй /үндэслэл болгосон 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн Биеийн тамир, спортын тухай хуулиар (шинэчилсэн найруулга) хүчингүй болсон, Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд спортын асуудал хамаарахгүй болсон/ хүчинтөгөлдөр үйлчилж буй дараах шийдвэрүүдийг хүчингүй болгох шаардлагатай бөгөөд хүчингүй болгох тушаалын төсөл, танилцуулгыг боловсруулан холбогдох яамдуудад хүргээд байна. Үүнд: Сангийн яаманд 2025.02.21-ний 1а/993 дугаар албан бичгээр Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2009 оны Журам шинэчлэн батлах тухай (Спортын их наадам, улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах, санхүүжүүлэх журам,	03	100 хувь

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээх, наадам зохион байгуулах, санхүүжүүлэх журам) 53/45 дугаар хамтарсан тушаалыг /Спортын сайдын жагсаалтад шилжсэн-2024 он/ Хууль зүй, Дотоод хэргийн сайдад 2025.02.21-ний өдрийн 1а/994 дүгээр албан бичгээр Эрүүл мэнд, спортын сайд, Хууль зүйн сайдын 2015 оны Буудлага үйлдэх байгууламж /ТИР/-д тавигдах шаардлага 433, А/248 дугаар хамтарсан тушаал, /Спортын сайдын жагсаалтад шилжсэн-2024 он/ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдад 2025.02.21-ний өдрийн 1а/991 дүгээр албан бичгээр Хууль зүйн сайд, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны Иргэний болон харуул хамгаалалтын ангилалд хамаарах галт зэвсэг, сумны нэр, төрлийн жагсаалт батлах тухай А/250, А/379,		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					437 дугаар хамтарсан тушаал, /Спортын сайдын жагсаалтад шилжсэ89-1-2024 он/ Хууль зүй, дотоод хэргийн сайдад 2025.02.21-ний өдрийн 1а/994 дүгээр албан бичгээр Эрүүл мэнд, спортын сайд, Хууль зүйн сайдын 2015 оны Журам батлах тухай /Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг эзэмших, хадгалах журам/ 468, А/268 дугаар хамтарсан тушаал /Спортын сайдын жагсаалтад шилжсэн-2024 он/ Боловсрол, шинжлэх ухааны сайдад 2025.02.21-ний өдрийн 1а/994 дүгээр албан бичгээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2019 оны Журам батлах тухай /спортын клубыг магадлан итгэмжлэх/ А/178 А 144 дүгээр тушаал /Спортын сайдын		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					жагсаалтад шилжсэн-2024 он/ тус тус хүргүүлсэн. Дээрх тушаалуудыг хүчингүй болгохоор холбогдох яамдуудад хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй буюу эрх зүйн зохицуулалтгүй болно гэсэн шалтгаанаар хүчингүй болгоогүй байна. Мөн хуульд нийцүүлэн батлах талаар Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд С.Номинд 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 1а/978 дугаар албан бичгээр хүргүүлсэн болно.		
4.	Арга хэмжээ 1.4. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн мэдээний санг хөтөлж, яамны вэб-д байршуулна.	Шинээр тогтмол баяжилт хийсэн мэдээний сан		ЭМЯ-ны вэб хуудаст байршуулсан байна.	ЭМЯ-ны вэб хуудасны эрх зүй булангийн захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр хэсэгт 1 болон 6 дугаар сард бүртгэлийн санг шинэчлэн байршуулсан.	01, 12	100 хувь

Зорилт 2. "Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, яамны албан хаагчдад хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх, мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа"

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
5.	Арга хэмжээ 2.1. Яамны албан хаагчдад хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Хууль, эрх зүйн зөвлөгөө өгсөн тоо	100	Сайд, Төрийн нарийн бичгийн дарга, аппаратын ажилтнуудад хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлсэн байна.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын зарим тогтоолууд, тушаал шийдвэрийн боловсруулалтын талаар тухай бүр давхардсан тоогоор 40 гаруй албан хаагчдад хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлсэн байна.	01- 12	100 хувь
6.	Арга хэмжээ 2.2. Яамнаас боловсруулж байгаа хууль, тогтоомжийн төслийг хянаж санал өгнө.	Хянаж санал өгсөн шийдвэрийн тоо	5	Эрүүл мэндийн яамнаас боловсруулж буй хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төслүүдийг боловсруулахад эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг, санал өгсөн байна.	Эрүүл мэндийн яамнаас боловсруулж Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлж батлуулсан Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2025 оны хувь хэмжээг тогтоох тухай Засгийн газрын 2025 оны 02 дугаар тогтоолын төслийг хянаж, шийдвэрийн төслийг боловсруулахад эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг, санал өгсөн.	01-12	100 хувь
7.	Арга хэмжээ 2.3. Бусад яам, холбогдох	Санал боловсруулсан	238	Хууль тогтоомжийн төслийг судалж	Эхний хагас жилийн байдлаар бусад яам, холбогдох газруудаас ирсэн 123 хууль тогтоомжийн төслийг судалж санал	01-12	100 хувь

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	газруудаас ирсэн хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төсөлд дангаар буюу холбогдох газар, хэлтэстэй хамтарч санал өгнө.	хууль тогтоомжийн тоо		санал боловсруулж хүргүүлсэн байна.	боловсруулж, албажуулан хүргүүлсэн байна.		
Зорилт 3. Эрх зүйн маргаанд Эрүүл мэндийн яамыг төлөөлөн оролцох үйл ажиллагаа							
8.	Арга хэмжээ №3.1. Эрх зүйн маргаанд ЭМЯ-ыг төлөөлөн оролцох	Шийдвэрлэгдсэн шүүх хуралдааны тоо	7	Итгэмжлэлийн дагуу нэхэмжлэлийг гардаж авах, хариу тайлбар, нотлох баримт гаргаж өгч, Эрх зүйн аливаа маргааныг хуулийн дагуу шийдвэрлүүлсэн байна.	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэгдсэн Ш.Уранцэцэгийн нэхэмжлэлтэй Эрүүл мэндийн яаманд холбогдох хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон. Шүүхээс нэхэмжлэлийн хувийг гардаж авч, Эвлэрлийн гэрээ байгуулж, Ш.Уранцэцэгт 5,022,259 төгрөгийг олгуулж шийдвэрлэсэн. Санчир-Ундрах ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон шүүх хуралдаанд оролцсон. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон Монгол Улсын дээд шүүхийн тогтоолоор Санчир-Ундрах ХХК-ийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.	01-12	100 хувь
Зорилт 4. “Олон улсын конвенцийн тайлангийн нэгтгэлийг хийж, холбогдох байгууллагад хүргүүлэх”							

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
9.	Арга хэмжээ 4.1. Эрүүл мэндийн чиглэлээр Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцийн тайланг нэгтгэнэ.	Хэрэгжилтийг гаргуулсан конвенцийн тоо	2	Холбогдох газруудаас конвенцийн хэрэгжилтийг гаргуулсан байна.	Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газар, Эмнэлгийн тусламжийн бодлогын газраас Монгол Улсын нэгдэн орсон олон улсын олон талт гэрээгээр хүлээсэн үүргийн талаарх биелэлтийг 2024 оны 359 дугаар дотоод меморандумаар гаргуулан авч нэгтгэсэн.	12-01	100 хувь
10.	Арга хэмжээ 4.2. Конвенцийн тайланг холбогдох байгууллагад хүргэнэ.	Нэгтгэгдсэн тайлангийн тоо	2	-	Гадаад харилцааны яамны гэрээ, эрх зүйн газарт 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 2/5632 дугаар албан бичгээр Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенци, Тамхины хяналтын тухай суурь конвенцийн хэрэгжилтийн тайланг хүргүүлсэн. 2025 оны тайланг 2026 оны 1 дүгээр сард хүргүүлнэ.	01 12	100 хувь
Зорилт 5. “Нууц хамгаалах ажилтны чиг үүргийн хэрэгжилт”							
11.	Арга хэмжээ 5.1. Нууц хамгаалах ажилтны чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Хариутай нууц бичгийн шийдвэрлэлтийн хувь	100%	Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж хэрэгжсэн байна.	Нууцын журмаар ирсэн, явсан албан бичгийн бүртгэлийг хөтөлж, холбогдох албан тушаалтанд танилцуулах, бүртгэлийн дугаар олгох, холбогдох байгууллагад хүргэж өгөх ажлыг хийж гүйцэтгэсэн. Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Эрүүл мэндийн яамны 2024 онд хийсэн ажлын тайланг Тагнуулын	01-12	100 хувь

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					Ерөнхий газарт нууцын журмаар албан бичгээр хүргүүлсэн. Нууц баримт бичигтэй танилцах эрх бүхий Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга Л.Баттөр, Стратеги төлөвлөлтийн газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн бодлогын хэлтсийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан Л.Намхайноров, албан хаагчдын шилжилт хөдөлгөөнийг ТЕГ-рт энэ оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 2/2746 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Эрүүл мэндийн яам болон харьяа байгууллагад хадгалагдаж байгаа байгаа нууц баримт бичгүүдийг нэгтгэх, Төрийн болон албаны нууцтай харилцах албан хаагчдын нууцын талаарх мэдлэгийг тогтоох, нууцын биет хадгалалт хамгаалалт, 2017 оноос хойш хувийн хэргээр гадаад улсад зорчсон зэрэг мэдээ, мэдээллийг нэгтгэж ТЕГ-рт хүргүүлэхээр ажиллаж байна. Мөн ТЕГ-аас ирүүлсэн жилийн эжсийн тайлан мэдээг ирүүлэх зааварчилгааг харьяа байгууллагуудад 2025 оны 05 дугаар сарын 23-ны 2/2724 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					Дээрх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлснээр төрийн болон албаны нууцыг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг хангах, нууц албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулж хэрэгжүүлсэн нь Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж хэрэгжиж байна.		
12.	Арга хэмжээ 5.2. Төрийн болон албаны нууцтай танилцах албан хаагчдыг аюулгүй байдлын шалгалтад хамруулна.	Төрийн болон албаны нууцтай танилцах албан хаагчдын холбогдох материалыг бүрдүүлж, албан бичиг төлөвлөгдөж, албажсан байна.	1	ТЕГ-т холбогдох албан тушаалтнуудын материал хүргэгдсэн байна.	Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын дарга О.Энхболд, Нууц хамгаалах ажилтны түр эзгүйд орлон ажиллах Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Түвшинбаяр, Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын БЗДХ/ДОХ/Сүрьеэ, вируст гепатит хариуцсан мэргэжилтэн Ч.Ариунболор, Стратеги төлөвлөлтийн газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн бодлогын хэлтсийн Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, худалдан авалтын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн И.Баяржаргал, Стратеги төлөвлөлтийн газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Намхайноров	01-12	90 хувь

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
					нарын нийт 5 албан хаагчийг ТЕГ-рт холбогдох материалыг хүргэж аюулгүй байдлын шалгалтад хамруулж, нууц задруулахгүй баталгааг гаргуулж авав.		
13.	Арга хэмжээ 5.3. 2024 оны нууцын журмаар ирсэн, явсан албан бичгийн архивын нэгж үүсгэн, архивлана.	Шинээр бүрдүүлсэн архивийн нэгж	100%	Холбогдох хууль журмын дагуу архивласан байна.	2024 оны нууцын журмаар ирсэн, явсан албан бичгийн товъёог үйлдэж, архивын нэгж үүсгэн архивласан.	02	100 хувь
14.	Арга хэмжээ 5.4. Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг шинэчлэн боловсруулж, сайдын тушаалаар батлуулна.	Батлагдсан тушаалын тоо		Сайдын тушаал батлагдсан байна.	Эрүүл мэндийн яамны зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдсэнтэй холбоотойгоор тус яамны Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн “Жагсаалт батлах тухай” А/17 дугаар тушаалаар батлуулсан.	01	100 хувь
	Зорилт 6. “Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх”						
15.	Арга хэмжээ 6.1. Өөрт хувиарлагдсан	Хугацаанд нь шийдвэрлэсэн	-		Өөрт хувиарлагдсан Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газрын Өрх, сумын эрүүл мэндийн тусламж,	01-12	100 хувь

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	өргөдөл, гомдлыг шийдвэрлэнэ	өргөдөл, гомдлын тоо		Өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлэсэн байна.	үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Ж.Нурботагаас ирүүлсэн өргөдлийг судлан үзэж, шүүхийн байгууллагад ахнадах талаар албан бичгийг төлөвлөж, албажуулан 2025 оны 06 дугаар сарын -ны өдрийн тоот албан бичгээр хариуг хүргүүлэв.		
16.	Арга хэмжээ 6.2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, хэм хэмжээг мөрдөнө	Ёс зүйн зөрчлийн тоо	-	Ёс зүйн зөрчил гаргаагүй байна	2025 онд ёс зүйн зөрчил гаргаагүй.	01-12	100 хувь
17.	Арга хэмжээ 6.3. Хөрөнгө орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт гаргана.	Хүргүүлсэн ХОМ-ийн тоо	100%	Хугацаанд нь гаргасан байна.	Хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд нь үнэн, зөв гаргаж АТГ-рт хүргүүлсэн.	01	100 хувь
18.	Арга хэмжээ 6.4. Сайд, Дэд сайд, ТНБД, газрын даргаас өгсөн хуульд нийцсэн шуурхай үүрэг даалгаврыг цаг	Нэмэлтээр өгсөн шуурхай үүрэг даалгаварын хугацаанд нь гүйцэтгэсэн тоо	-	Нэмэлтээр өгсөн үүрэг даалгаварыг хугацаанд нь гүйцэтгэсэн байна.	Эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулах Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/43 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж байна. Ажлын хэсэг уг хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан Эрүүл	01	100 хувь

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	хугацаанд гүйцэтгэх нь				мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан. Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн хүрээнд Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төрийн албаны шинэтгэл болон сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн албаны зөвлөлийн даргын баталсан 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаар тушаалын дагуу Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газрын дарга Т.Сосорбарамар ахлуулсан баг Дундговь аймгийн Хулд, Дэлгэрхангай, Сайхан-овоо Өмнөговь аймгийн Номгон, Хүрмэн, Баяндалай, зарим сумдын төрийн албан хаагчдад сургалт, мэдээлэл өгөх, соён гэгээрүүлэх, хяналт, шалгалт хийх, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах чиглэлээр энэ оны 02 дугаар сарын 16-27-ны өдрүүдэд ажиллав.		

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. ТАЗ-ийн 7 хоног бүрийн цахим сургалтад оролцоно.	Оролцсон цахим сургалтын тоо	100%	Тухай бүр	2025 онын эхний хагас жилд Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн цахим сургалтыг зохион байгуулаагүй. Харин Төрийн албаны зөвлөлийн даргын баталсан 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаар тушаалын дагуу Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газрын дарга Т.Сосорбараммаар ахлуулсан ажлын хэсэг Өмнөговь, Дундговь аймгийн зарим сумдаар ажиллахад уг аймгийн төрийн албан хаагчдад хийсэн төрийн албаны тухай хууль тогтоомж, цахим орчин, төрийн албаны шинэтгэл сэдэвт сургалтад байнга оролцсон.	01-12	
2.	Арга хэмжээ 2. Албан тушаалын онцлогоос хамаарсан гадаад хэл, мэдээллийн технологийн болон салбарын хууль тогтоомжид заасан зайлшгүй шаардлагатай ур чадварыг мэргэжлийн байгууллагаар дамжуулж, эсхүл бие даан суралцаж эзэмших Яамнаас зохион байгуулсан сургалтад оролцоно.	Оролцсон сургалтын тоо	100%	Тухай бүр	Энэ оны 04 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулагдсан Дайчилгааны тухай хуулийн хэрэгжилтийг хангах сургалтад, Гамшигийн бэлэн байдлыг хангах чиглүүлэх сургалт, 3 сарын 21-нд Албан хэрэг хөтлөлт, монгол бичгийн стандарт сургалт, төрийн албан хаагчийн ёс зүй сэдэвт сургалтад тус тус оролцсон. Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс энэ оны 5 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд” Стресс менежмент” сэдэвт сургалтад хамрагдаж, сертификат авсан. Мөн Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс зохион байгуулсан Захиргааны хэм хэмжээний актын эрх зүйн боловсруулалт, түүнд хяналт тавих нь сэлэвт сургалтад хамрагдсан.	01-12	100 хувь

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТЗУГ-ын Хуулийн хэлтсийн
Салбарын хууль эрх зүйн
зохицуулалт хариуцсан ахлах
шинжээч

(Албан тушаал)

 / Ш.Мөнгөнцэцэг /

(Нэр, гарын үсэг)

2025.06.10

(Огноо)